



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

**Г ГЭР БҮЛ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭНХ-ЭРДЭНЭ ТАНАА**

2018.02.28 № 06/24
танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

108

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**ГЭР БҮЛ ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг: otuya_099@yahoo.com

Аудитор: Т.Алтанзул
Утас: 70562147
Цахим хаяг: altanzult@audit.gov.mn

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн сум
3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас: Khentii@audit.gov.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/129/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Т.Алтанзул хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 05-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын эрхэм зорилго нь Гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрх хөгжил, хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах, залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог дэмжин сайжруулах явдал юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаас олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 6 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 82.60 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 81.97 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 0.62 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусгана.

Завсрын аудитаар Шилэн дансны дараах мэдээллийг дутуу байршуулсан байна. Үүнд:

- 6.1.2. Төсвийн гүйцэтгэл 1-9 сарын мэдээг зөрүүтэй
- 6.1.3. Дараа жилийн төсвийн төсөл
- 6.1.5. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- 6.1.6. Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар
- 6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 11.3 сая төгрөгийн 1 гүйлгээ, орлогын 129.3 сая төгрөгийн 12 гүйлгээ
- 6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 25.2 сая төгрөгийн 12 шийдвэр зэргийг мэдээллээгүй байна. Энэхүү мэдээллийг цаашид хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 7 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баримталж ажилладаггүй, авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй, түрээсийн орлогын суутган төлбөрийг төвлөрүүлдэггүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

112

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. ЛАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Скайтел ХХК-тай байгуулсан 2017 оны 05-р сарын 24-ний өдрийн ТЛ-357/17 тоот гэрээний дагуу Хүүхэд хөгжлийн төвийн байрны дээврийн талбайд тоног төхөөрөмж байршуулсаны 2166,7 мянган төгрөгийн түрээсийн орлогоос суутган тооцож төсөвт төвлөрүүлэх 30% болох 650.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна

Шийдвэрлэсэн: Түрээсийн орлогоос суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй 650.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 2808.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн: Тайланд бүртгэлтэй байгаа 2808.8 мянган төгрөгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээг авах зөвлөмж өгөв.

3. Санхүүгийн үйл ажиллагаандаа НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн: НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг 3458.8 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулах шаардлагагүй гэж үзлээ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 650.0 мянган төгрөгийн 1 алдаанд төлбөрийн акт тогтоож, бодлогын

111

бичиг баримт боловсруулж ажиллаагүй болон санхүүгийн тайланд тусгагдсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 2808.8 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн урьдчилгаа дутуу тооцсон 100.0 мянган төгрөг, ХХОАТ-ыг дутуу тооцсон 35.0 мянган төгрөгийн 2 акт тавьж зөвлөмж өгсөн ба холбогдох хүмүүсээс нь нөхөн суутгаж Аймгийн төрийн сан дахь Нэр заагдаагүй бусад орлогын 180000955 тоот дансанд тушааж зөвлөмжийг 100% биелүүлж ажилласан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт


Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 7 хуудас, аудитын гэрчилгээ 2 хуудас менежментийн захидал 4 хуудас байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг


Хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор



/ Ч.Эрдэнэбаатар/


Аудитын менежер




/ Д.Оюунтуяа/

Бэлтгэсэн:

Аудитор



/ Т.Алтанзул/



Огноо: 2018.02.28

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар

115

**ГЭР БҮЛ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Бодлогын баримт бичгийн талаар
.....2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Дансны авлагын талаар
.....3

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Б.Энх-Эрдэнэ, нягтлан бодогч Д.Ганзул нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

Санхүүгийн үйл ажиллагаандаа НББ-ын бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй нь Монгол улсын НББ-ийн тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү НББ-ийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлаж мөрдөж ажиллана” 19 дүгээр зүйлийн 19.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах үүргийг нягтлан

АГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмж өгөх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангаа олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв тайлагнахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АГ-ын ажиглалт

Санхүүгийн тайланд тусгагдсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 2808.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь НББ-ын тухай хуулийн 22.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай хийх тооцооны тооллогыг зохион байгуулах, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

АГ-ын зөвлөмж

Авлагын дансанд бүртгэлтэй байгаа 2808.8 мянган төгрөгийн авлагын асуудлыг судлан нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээг авах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
Найдваргүй авлага үүсэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ


ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Т.АЛТАНЗУЛ

Огноо: 2018.02.28